

## ЖҮ ДЭ ЖАНЖИН

ДУРСГАЛТ ХҮМҮҮСИЙН ОЙ

Л. БЭГЗЖАВ

Аугаа их Октябрийн социалист хувьсгалын чөлөөлөх үзэл санаа Дорнодахины дарлагдсан ард түмний үндэсний ухамсарыг нойрноос сэрээж, тэднийг үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд уриалан дуудсан билээ. Олон сая хүн амтай, хагас колони, хагас феодалын Хятад оронд ард түмний хувьсгалт тэмцэл өрнөсөн юм. Энэ тэмцэлд гар бие оролцож, ард түмнийхээ эрх чөлөө, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцсэн Хятадын олон арван хувьсгалч, эх оронч, коммунистын нэр алдар түүхэнд үлджээ. Ийм хувьсгалчдын тоонд Хятадын Ардын чөлөөлөх Армийг үндэслэгч, зохион байгуулагч, удирдагчдын нэг нэрт жанжин Жү Дэ зүй ёсоор орно.

Жү Дэ 1886 оны арванхоёрдугаар сарын 1-нд Сычуань мужийн Илун хошууны Маань тосгонд төржээ. Түүний бага насны амьдрал феодалын ноёрхолд байсан Хятадын ард түмний хүнд хэцүү байдлаас ангид байсангүй. Ийм амьдрал дунд өсч бойжсон боловч Жү Дэ тосгоны, дараа нь Чэнду хотод багшийн сургуульд суралцан, төрсөн тосгондоо биеийн тамирын багшаар ажиллаж байв. 1909 онд 24 настай Жү Дэ цэргийн сургуульд орохоор хоёр сар явган явж, Хятадын өмнө зүгийн Юньнаньд очжээ. Тэндэхийн цэргийн дунд сургуульд ихэнхдээ уугуул нутгийн хүмүүсээс авч байсан тул Жү овогт Дайчжан хэмээх нэрээ Жү Дэ хэмээн өөрчилж, тэр цагаас хойш энэ нэрээрээ алдаршсан ажээ.

Жү Дэ цэргийн сургуульд суралцаж байх үедээ 1910 онд хувьсгалт ардчилсан үзэлтэн Сунь Ятсений байгуулсан хувьсгалт нууц байгууллага «Тунмэнхуэй» («нэгдсэн холбоо»)-д элсэн орж, Манж Чин гүрний ноёрхлыг эсэргүүцэн тэмцэж, улмаар 1911 оны Синьхайн (цагагчин гахай жилийн хувьсгалд идэвхитэй оролцсон байна. Синьхайн хувьсгал бүхэлдээ дэвшилт шинжтэй байсан боловч империализм, феодализмын дарлалаас Хятад орон, ядуу зүдүү, эрх мэдэлгүй байдлаас ард түмэн нь ангижирч чадаагүй билээ. Тиймээс ч Жү Дэ Синьхайн хувьсгалын ололтыг булаан авсан Юань Шикайн харгис засгийн эсрэг тэмцэж байлаа. Тэмцэлд анх орсон цагаас эхлэн Жү Дэ-гийн цэргийн авьяас чадал тодорч, 6 жилийн дотор тэрээр аж ахуйн салааны ахлагчаас генерал цолтой, бригад командлагч болтлоо дэвжээ.

Хятадын милитарист бүлэглэлийн хоорондох зөрчил тэмцэлдээн тус орны эдийн засгийн хүч чадлыг доройтуулж, ард түмнийг улам бүр туйлдуулж байлаа. Улс орны доторхи энэ хямрал Жү Дэгийн оюун санаанд нөлөөлөхгүй байж чадсангүй. Тэрээр ард түмнийхээ аз жаргалын төлөө амьдрал тэмцлээ зориулахаар шийдэж 1922 онд Хятадын хувьсгалт хөдөлгөөний гол төв болж байсан Шанхайд очжээ. Коммунистуудтай холбоо тогтоох гэсэн «хуучин армийн генерал» Жү Дэг зарим хүмүүс үл итгэсэн байдлаар угтжээ. Гэвч мөн онд 36 настайдаа Жү Дэ Хятадын хэсэг оюутны хамт Германд очиж, Геттингений их сургуулийн нийгэм судлал-гүн ухааны факультетэд суралцлаа. Энд байхдаа Жү Дэ анх удаа марксизм-ленинизмын сургаал, аугаа их октябрийн хувьсгалын туршлагатай танилцаж, 1922 оны 11-р сард ХКН-ын Европын секцэд гишүүнээр элссэн байна. Жү Дэ улс төрийн ухаан, цэргийн эрдэмд шамдахын зэрэгцээ «Эв хамт намын тунхаг», «Төр ба хувьсгал», «Коммунизм

дахь зүүний нялхасын өвчин» зэрэг марксист ном зохиолыг гүнзгийрүүлэн судалж, улмаар эх орон нэгт хятад оюутнуудын дотор коммунист үзэл санааг сурталчилж, хувьсгалт нууц ажилд идэвхитэй оролцож байлаа. Октябрийн хувьсгалын нөлөө газар сайгүй түгж, Европын олон орон, тэр дундаа Германд ч хүчтэй нэвтэрч байсан тэр үед Жү Дэ-гийн улс төрийн үйл ажиллагааг Германы цагдаагийн газар хориглон, түүнийг хоёр удаа баривчилсан бөгөөд 1925 онд Германаас хөөн явуулжээ. Хувьсгалч нөхдийнхөө тусламжтайгаар Жү Дэ дэлхийн ууган социалист орны нийслэл Москва хотноо ирж суралцав. Жү Дэ ЗХУ-д ганцхан жил байхдаа марксист ленинист онол, Зөвлөлтийн Улаан армийн туршлагыг судалж, шинэ нийгэм байгуулж буй Зөвлөлтийн ард түмний амьдралтай ойр дотно танилцсан явдал түүний хувьсгалт тэмцэл, ертөнцийг үзэх үзэлд багагүй нөлөөлсөн юм.

Марксист ленинист улс төрийн өргөн мэдлэг, цэргийн онолын бэлтгэлтэй болсон Жү Дэгийн авьяас билэг ХКН-аас гоминьданыханы хувьсгалын эсэргүү үйл ажиллагааны эсрэг өрнүүлсэн тэмцлийн явцад онцгой тодорчээ. 1927 оны наймдугаар сарын 1-ий Наньчаны бослогыг удирдан, зохион байгуулагчийн нэг нь Жү Дэ байлаа. Энэ өдөр Хятадын Улаан армийн (Хятадын Ардын Чөлөөлөх Армийн) үүсч байгуулагдсан өдөр болсон билээ.

1925—1927 оны Хятадын хувьсгал, ардчилсан хөдөлгөөн түр зуурын ялагдал хүлээж, гоминьданыхан цэргийн илт давуу байдлаа ашиглаж коммунистуудын эсрэг харгис аллага хядлага явуулж байсан тэр хүнд бэрх нөхцөлд Хятадын улаан арми үүсэн бий болж, тэмцлийн дунд бэхжин хатуужсан нь Хятадын хувьсгалын цаашдын өрнөлтөд үлэмж ач холбогдолтой болсон юм.

1931 онд Жү Дэ Хятадын ажилчин тариачны Улаан армийн ерөнхий командлагчаар томилогджээ. Хятадын милитарист бүлэг, Чан Кайшийн харгис дэглэм, Японы түрэмгийлэгчдийн эсрэг тэмцлийн урт удаан, хүнд бэрх замыг туулсан Хятадын улаан армийг байгуулж, бэхжүүлэх тэмцлийн зорилт, цэргийн стратеги тактик боловсруулах, удаа дараагийн баатарлаг ялалт байгуулахад Жү Дэ томоохон хувь нэмэр оруулсан юм. Ерөөс Хятадын Ардын Чөлөөлөх Армийн бүхий л түүх, байлдааны дайчин замнал Жү Дэ-гийн нэртэй холбоотой.

1930—1934 онд империалист түрэмгий хүчний дэмжлэгээр гоминьданыханаас Хятадын Улаан арми, Зөвлөлт районы эсрэг явуулсан хэд хэдэн удаагийн том давшилтыг бут цохиход Жү Дэгийн оруулсан хувь нэмэр их юм.

Тэр үед Жү Дэгийн толгойг авсан хүнд 250 мянган доллар өгөхөөр гоминьданчууд амлаж байсан удаатай. 1937—1945 онд Японыг эсэргүүцсэн дайны жилүүдэд Жү Дэгийн удирдлагаар үндэсний эрх чөлөөний дайн өрнөж, Хойд Хятадад чөлөөлөгдсөн районууд байгуулагдаж байсан нь Японы түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд, мөн Хятад дахь хувьсгалт хүчнийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Жү Дэ 1945 оны наймдугаар сараас ХАЧА-ийн ерөнхий командлагчаар томилогдон, америкийн империализмаар дэмжүүлсэн гоминьданы хантай хийсэн ардын чөлөөлөх дайнд, улмаар Хятадад ардын хувьсгал ялахад чухал хувь нэмэр оруулсан юм. Дайн тулааны хүнд бэрх жилүүдэд ард түмэндээ домог болон алдаршсан Жү Дэ БНХАУ-ын арван маршалын анхных бөгөөд БНХАУ-ын төрийн дээд шагнал болох «Наймдугаар сарын нэгэн», «Эрх чөлөө, тусгаар тогтнол», «Чөлөөлөлт» нэгдүгээр зэргийн одонгоор шагнагдаж байлаа.

Жү Дэ цэргийн жанжин төдийгүй нам, төрийн томоохон зүтгэлтэн байв. 1934 оноос амьдралынхаа сүүлчийг хүртэл 40 гаруй жил ХКН-ын

Төв Хорооны Улс төрийн товчооны бүрэлдэхүүнд, 1945 онд ХКН-ын VII их хурлаар ХКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, 1956 онд ХКН-ын VIII их хурлаар ХКН-ын орлогч даргаар сонгогдож байлаа.

БНХАУ байгуулагдсаны дараа Ардын Төв засгийн газрын орлогч дарга, БНХАУ-ын орлогч дарга, Улсыг Батлан хамгаалах хорооны орлогч дарга, 1959— 1976 онд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны даргын өндөр албан тушаалд ажиллаж байхсан юм.

Жү Дэ нам, төр, цэргийн бүхий л албан тушаалд ажиллаж байхдаа марксизм-ленинизмийн үндсэн дээр намын эв нэгдлийг хамгаалахын төлөө тэмцэж, коммунист хүний зарчимч, чанд сахилга, туйлбартай байдлын үлгэр жишээ болж байлаа. Тэрээр «Ленинизм бол Хятадын ард түмний социализм байгуулах тэмцлийн туг мөн» өгүүлэлдээ: «Хятадын хувьсгалын ялалт бол Ленинизмийн ялалт мөн» гэдгийг цохон заагаад «Манай аугаа их холбоотон ЗХУ-ын улам зузаарсаар байгаа хүч чадал ба түүний сэтгэл харамгүй тусламж нь хятад оронд социализм байгуулахад маш тохиромжтой нөхцлийг Хятадын ард түмэнд олгож байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй» гэж бичсэн байдаг.

ЗХУ, ах дүү социалист орнуудтай БНХАУ-ын тогтоосон найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэн бататгахыг Жү Дэ ямагт эрхэмлэдэг байлаа. 1956 оны гуравдугаар сарын 28-31-нд БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Засгийн газрын урилгаар БНХАУ-ын орлогч дарга маршал Жү Дэ БНХАУ-ын засгийн газрын төлөөлөгчдийг тэргүүлэн манай оронд ирж байлаа. Жү Дэ монголын ард түмэнтэй уулзан ярилцахдаа хоёр орны ард түмний найрамдал, хамтын ажиллагаа, манай орны энх тайванч гадаад бодлогыг өндөр үнэлж байсан билээ.

Манай оронд Жү Дэг цэргийн нэрт жанжин, Хятадын ард түмний үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө мятаршгүй тэмцэгч, бүхий л амьдралаа Хятадын хувьсгал, тус орон дахь социализмын үйл хэргийн төлөө зориулсан хүн гэдгийг сайн мэддэг бөгөөд түүний шудрага үйл хэргийг хүндэтгэн дурсдаг юм.